



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

**НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙГ
ХЭМЖИЖ БУЙ БАЙДАЛ**

/Харьцуулсан судалгаа/

Ц.Тэгшжаргал¹, Н.Өлзийханд², Б.Гэрэлцэцэг³

**Улаанбаатар
2021 он**

¹ ҮСХ, Үндэсний тооцоо, шинжилгээ судалгааны газрын статистикч

² ҮСХ, Үндэсний тооцоо, шинжилгээ судалгааны газрын ахлах статистикч

³ ҮСХ, Үндэсний тооцоо, шинжилгээ судалгааны газрын статистикч

Хураангуй

Нийгмийн хөгжил дэвшлийн тухай ойлголт нь нарийн төвөгтэй олон талт асуудлыг хамардаг. Нийгмийн хөгжил дэвшлийн тухай ойлголтод хувь хүний материаллаг болон материаллаг бус хэрэгцээний асуудлыг авч үзнэ.

Хувь хүний материаллаг хэрэгцээнд байр орон сууц, хоол хүнс, орлого зэрэг олон зүйл багтах бол материаллаг бус хэрэгцээнд нийгмийн харилцаа, соёл урлаг, нийгмийн үнэт зүйлс, эрүүл цэвэр орчин зэрэг зүйлс багтана.

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) нь улс үндэстнүүдийн хөгжлийн ерөнхий түвшинг харуулдаг чухал үзүүлэлт байсаар ирсэн. ДНБ нь эдийн засгийн үйлдвэрлэл, хэрэглээ, хуримтлалын үе шатууд ба нийгмийн хөгжлийн материаллаг байдлыг харуулдаг. Гэхдээ материаллаг бус байдлыг хэмжиж чаддаггүй гэж үздэг.

Дэлхийн нэрт эдийн засагч, эрдэмтэд ДНБ-ий сул талуудыг авч үзэх шаардлагатай гэж үздэг бөгөөд тэдгээрийн төлөөлөл Америкийн эдийн засагч, нобелийн шагналт Саймон Кузнец “ДНБ нь хэзээ ч нийгмийн сайн сайхан байдлын хэмжигдэхүүн болж байгаагүй” гэж хэлсэн байдаг.

Сүүлийн жилүүдэд нийгмийн хөгжил дэвшлийг дан ганц ДНБ буюу эдийн засгийн бодит өсөлтөөр хэмжихээс илүүтэйгээр ард иргэдийн сайн сайхан аж байдлыг хэмжих нэгдсэн үзүүлэлт, индексийг тооцож бодлого боловсруулалт, төлөвлөлт, шийдвэр гаргалтад ашиглаж байна.

Энэхүү судалгааны ажлаар хөгжил, дэвшлийг хэмжихэд ашиглаж буй үзүүлэлтийг улс орнуудын хувьд харьцуулан судалж, Монгол Улсын хувьд ямар үзүүлэлтүүд байж болох талаар авч үзнэ.

Түлхүүр үгс: хөгжлийн үзүүлэлт, сайн сайхан байдал, нийгмийн хөгжил, нийлмэл индекс

JEL ангилал: P00, P52, R50

Нэг. Удиртгал

Нийгмийн хөгжил дэвшлийн тухай ярихын тулд нийгмийн, эдийн засгийн, байгаль орчны болон засаглалын хэмжээснүүдийн талаар авч үзэх шаардлагатай байдаг. Хөгжил дэвшлийн эцсийн зорилго бол тогтвортой байх, өөрөөр хэлбэл, ирээдүй хойч үедээ үр өгөөжтэй байх явдал юм.

Эдийн засгийн үйлдвэрлэл нь нийгмийн хөгжлийг өргөн хүрээгээр харуулахаас гадна материаллаг байдлыг илэрхийлэх гол хэрэгсэл болдог. Энэ үүднээс авч үзвэл ДНБ-ийг нийгмийн хөгжлийг хэмжих зайлшгүй хэмжүүр гэж үзэж болох ч нийгмийн сайн сайхан байдлыг бүрэн тодорхойлж чаддаггүй гэж үзсэн.⁴ Тэгвэл сайн сайхан байдлыг ямар хэмжүүрээр хэмжих вэ? гэсэн асуулт гарч ирсэн.

Сүүлийн жилүүдэд нийгмийн сайн сайхан байдлыг хэмжихэд ДНБ-ээс давж гарах илүү өргөн хүрээг хамарсан үзүүлэлтийг бий болгох чиглэлээр маш олон санал санаачилгууд гарч ирсэн. Тухайлбал, 1968 онд байгаль орчны асуудлыг гаргаж ирсэн Ромын клуб, өрхийн бизнест цалин хөлсгүй ажиллах байдлыг эсэргүүцсэн эмэгтэйчүүдийн хөдөлгөөн, 1970- аад оноос НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс гаргасан Хүний хөгжлийн индекс, 1980-аад оноос Канадын олон нийтийн судалгааны анхдагч төсөл болох Канадын сайн сайхан байдлын индекс (Canadian index of wellbeing) зэргийг нэрлэж болох юм.

Олон жилийн туршид эдгээр янз бүрийн хөдөлгөөн санаачилгууд нь ихэвчлэн тус тусдаа хөгжиж ирсэн байна. Италийн эдийн засагч, статистикч Энрико Жованнинигаар удирдуулсан ЭЗХАХБ-ын дэргэд “Нийгмийн хөгжлийг хэмжих нь” гэсэн нэртэй Глобал төсөл 2004 оноос хэрэгжиж эхэлсэн нь нийгмийн сайн сайхан байдлыг хэмжих нэгдсэн үзүүлэлт гаргахад ахиц дэвшил болсон байна.

Энэхүү глобал төслийн гол зорилго нь нийгмийн хөгжлийн олон элементийг хэмжих нэгдсэн үзүүлэлт бий болгох, ДНБ-ээс давж гарах (beyond GDP) хөгжлийг хэмжих ямар үзүүлэлт байж болох талаарх хэлэлцүүлгийг өрнүүлэхэд чиглэсэн. Ингээд 2007 онд Истанбулд болсон ЭЗХАХБ-ын Дэлхийн форумд ЭЗХАХБ, НҮБ, Европын комисс, Дэлхийн банк зэрэг байгууллагуудын хамтарсан тунхаглалаар дээрх зорилтыг албан ёсоор тохиролцсон байна.⁵ Үүний дагуу дэлхийн бүх бүс нутагт санал санаачилгууд нээгдэж, мэдлэгийг дээшлүүлэх, хандлагыг өөрчлөх чиглэлээр олон ажил хийгдэж байна.

Энэ удаагийн судалгаагаар олон улсын түвшинд болон улс орнуудын түвшинд хөгжлийн үзүүлэлтийг хэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй санаачилгуудыг харьцуулан судалж, манай улсын хувьд ямар үзүүлэлтүүдээр нийгмийн хөгжлийг хэмжиж болох, тэдгээр үзүүлэлтүүд хэрхэн өөрчлөгдөж байгааг сүүлийн 10 жилийн тоон мэдээллийн хувьд авч үзнэ.

Уг судалгаа нь удиртгал, дэлхийн түвшний санал санаачилга ба улс орнуудын туршлага нэгдсэн индекс тооцож буй үзүүлэлтийн харьцуулалт, манай улсад хэрэгжүүлж буй туршлага, хөгжлийг хэмжих үзүүлэлтийн хувилбар, дүгнэлт гэсэн 5 хэсгээс бүрдэж байна.

⁴ Mike Salvaris, Measuring the Kind of Australia We Want: ANDI, the GDP and the Global Movement to Redefine Progress, Australian Economic Review, March 2013 v 46 no 1.

⁵ <http://www.oecd.org/site/worldforum06/istanbulworldforum-measuringandfosteringtheprogressofsocieties.htm>.

Хоёр. Нийгмийн хөгжлийг хэмжих чиглэлээрх санаачилга

Сүүлийн жилүүдэд ДНБ-ий тооцооноос гадна (beyond GDP) нийгмийн хөгжил дэвшлийг илүү өргөн хүрээнд харуулах үзүүлэлтийг бэлтгэн гаргах хандлага нэмэгдэж байна. Нийгэм хөгжиж эсвэл ухарч байгааг хэмжих маш олон санал санаачилга хэрэгжиж байна. Энэ санаачилгад олон улсын байгууллагууд, Засгийн газар, иргэний нийгмийн төлөөлөл, эрдэмтэн судлаачид, хувийн хэвшлийн байгууллагууд нэгдэж байна.

Дэлхий нийтийн хэмжээнд дараах санаачилгуудыг гаргасан байна. Үүнд:

- Австралийн Статистикийн газар. “Австралийн хөгжлийг хэмжих нь
- Австралийн хөгжлийн индекс,
- BES: benessere equo sostenibile (Итали)
- Аз жаргалын индекс (Бутан)
- Эдийн засгийн гүйцэтгэл ба нийгмийн дэвшлийг хэмжих комисс
- Сайн сайхан байдлыг хэмжих: ДНБ-ийг нөхөх W3 үзүүлэлт (Герман)
- Шинэ Зеландын нийгмийн тайлан (Шинэ Зеланд)
- Илүү сайн амьдралын индекс (Их британи)
- Шотландын сайн сайхан байдлыг бий болгоход бид юу хийж байна вэ, цаашид юу хийх ёстой вэ (Шотланд)
- Үндэсний гол үзүүлэлтийн систем (Key National Indicator system- АНУ)
- Дэлхийн сайн сайхан байдлын индекс рүү (Кени)
- Сайн сайхан амьдрах хүрээний талаар: Хойд Ирландын сайн сайхан байдлыг хэмжих дугуй ширээний ярилцлагын үр дүн
- Үндэсний сайн сайхан байдлыг хэмжих, (Их британийн Статистикийн газар)
- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Хүний хөгжлийн тайлан
- Ирландын сайн сайхан байдал: арга хэмжээ зохиох, бодлогыг хэрэгжүүлэх
- Израилын сайн сайхан байдлын үзүүлэлтүүд
- Википрогресс

Энд Австрали болон Канад улсын туршлагыг тусад нь бусад улсуудынхыг нэгтгэн харуулав.

Австрали улсын туршлага:

Австрали улс нь нийгмийн хөгжил дэвшлийг хэмжих асуудлыг санаачлан хэрэгжүүлсэн хамгийн анхны улс юм. 1990- ээд оны дунд үеэс Австралийн Сенат үндэсний хөгжил дэвшлийг хэмжих чиглэлээр санаачилга гаргасан бөгөөд “Хөгжил дэвшлийг хэмжих нь” сэдэвт олон талыг оролцуулсан үндэсний хэмжээний анхны хурлыг 1997 онд зохион байгуулсан байна. Үүний үр дүнд 1999 онд Австралийн Статистикийн дарга Деннис Тревинээр удирдуулсан “Австралийн хөгжлийг хэмжих нь” гэсэн санаачилгыг хөгжүүлж эхэлсэн байна. Энэхүү санаачилгаараа Австралийн Статистикийн газар нь ДНБ-ий хөгжлийг хэмжих дутагдалтай талыг хүлээн зөвшөөрсөн анхны байгууллага болсон төдийгүй эдийн засаг, нийгэм, байгаль орчин, ардчиллын үзүүлэлтийг багтаасан хөгжил дэвшлийг хэмжих үзүүлэлтийн хүрээг боловсруулсан байна. Энэ санаачилга нь ЭЗХАХБ-аас 2004 онд батлан гаргасан “Нийгмийн дэвшлийг хэмжих” дэлхий нийтийн санаачилгын гол хөшүүрэг болжээ.

“Австралийн хөгжил дэвшлийг хэмжих нь” санаачилга нь нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн үндсэн 3 хэсгийн 17 домайны хүрээнд нийгмийн хөгжлийг хэмжиж байсан.

Хүснэгт 1. “Австралийн хөгжлийн хэмжих санаачилга”-ын үзүүлэлтүүд

Нийгэм	Эдийн засаг	Байгаль орчин
<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэнд • Боловсрол • Ажил эрхлэлт • Гэмт хэрэг • Гэр бүл, бусад нийгмийн бүлэг • Ардчилал, засаглал 	<ul style="list-style-type: none"> • Үндэсний нийт орлого • Үндэсний баялаг • Өрхийн сайн сайхан аж байдал • Орон сууц • Бүтээмж 	<ul style="list-style-type: none"> • Биологийн олон янз байдал • Газар • Гадаргын ус • Далай тэнгис • Агаар мандал • Хог хаягдал

Эх сурвалж: Measures of Australia's Progress -2012. Is life in Australia getting better.

Австралийн Статистикийн газраас хэрэгжүүлж байсан санаачилга нь санхүүжилтийн асуудлаас болоод 2009 оноос зогссон. Харин түүний дараа Австралийн үндэсний хөгжлийн индекс гэсэн олон төлөөллийг оролцуулсан байгууллага нийгмийн хөгжлийг хэмжих үүргийг гүйцэтгэн ажиллаж байна. Энэ байгууллагыг одоогоор Melbourne-ийн их сургууль удирддаг бөгөөд төр, шинжлэх ухааны байгууллага, бизнесийн байгууллага, нийгмийн бүлгийн төлөөллөөс бүрдэх 60 гаруй байгууллагын төлөөлөл оролцон ажиллаж байна. Австралийн хөгжлийн индексийг тооцоход дараах 12 домайны хүрээнд мэдээлэл цуглуулж тооцож байна.

Зураг 1. “Австралийн үндэсний хөгжлийн индекс тооцоох үзүүлэлтийн хамрах хүрээ



Эх сурвалж: Australian National Index limited. Annual report: What kind of Australia do we want, ABN 13 160 688 077. 2019

Financial review сэтгүүлийн 2015 оны 3 сарын 5ны өдрийн дугаарт сэтгүүлч Жереми Тори 2015 онд гарсан Төрийн сангийн тайлангийн дөрөвдүгээр хувилбарт санхүүч Жо Хоккейдийн дэвшүүлсэн тэтгэврийн эрхийн асуудлыг авч үзэхдээ эдийн засгийн түүхээ дахин бататгаж байх талаарх асуудлыг авч үзсэн байна. Энэ тайланд гурван Р буюу хүн ам, оролцоо, бүтээмжийн талаар тооцож байсан таамаглал нь бодит амьдралтай нийцэхгүй байгааг дурдсан байна.

Тухайлбал, 2009 онд Big Australia-д 2055 он гэхэд Австралийн хүн ам 66 хувиар өсч 39.7 сая болно гэсэн таамаглал дэвшүүлж байжээ.

Хүн амын өсөлт нь дундаж наслалт уртсах, шилжилт хөдөлгөөн нэмэгдэх, төрөлтийн коэффициент зэргээс болж өсдөг. Хүн ам зүйн эдгээр хувьсагчдын хэлбэлзэл нь хүн амын өсөлтийн прогноз хийхэд бэрхшээлтэй талаар авч үзсэн байна. Жишээлбэл, 2002 оны тайланд Австралийн хүн амыг 2042 онд 25.3 саяд хүрнэ гэж таамаглаж байсан бол хамгийн сүүлийн тайланд дурдсанаар 2017 онд энэ тоонд хүрсэнийг дурджээ.

Энэ нийтлэлийн гол санаа санхүүч Жо Хоккейдийн хүн амын өсөлт, ажиллах хүчний оролцоо, хөдөлмөрийн бүтээмжийн талаарх урт хугацааны таамаглалын мэдээлэл нь төрөөс нийгэмд чиглэсэн бодлого хөтөлбөр боловсруулахад чухал ч хүн амын үзүүлэлт нь цаг хугацаанаас хамаарч өөрчлөгдөж байдаг тул төрөөс нийгмийн чиглэлээр авч хэрэгжүүлэх бодлого шийдвэрт урт хугацааны таамаглалыг ашиглах боломжгүй байдгийг Австралийн жишээгээр тайлбарлан харуулжээ.

Канад улсын түршлага:

Канадын сайн сайхан байдлын индексийг хөгжүүлэх санаачилга нь Онтарио мужийн Торонто дахь Аткинсон буяны сангаас (ACF) эхлэлтэй гэж үздэг. Аткинсон буяны сан 1999 онд нийгмийн үзүүлэлтийн судалгааны мэргэжилтнүүдийг нэгтгэсэн семинар зохион байгуулж, "Канадчуудын сайн сайхан байдлыг хэмжих хэрэгслийг бий болгохын тулд юу хийх хэрэгтэй вэ?" гэсэн асуултыг авч үзсэн. Үүнийг тодорхойлж хэмжихэд менежментийн хүчтэй бүтэц, санхүүгийн хангалттай дэмжлэг шаардагдана. Түүнчлэн хамгийн чухал асуудал бол үнэн зөв бодит байдлыг хангах маш сайн судалгааны бааз суурь хэрэгтэй гэж үзсэн. Үүний дагуу тус буяны сан нь 2000 онд Канадын сайн сайхан байдлын индексийг тооцох цогц үйл явцыг эхлүүлсэн. Энэ үйл явцад Канадын өнцөг булан бүрээс ирсэн мэргэжилтнүүдийн зөвлөгөө, олон нийтийн хэлэлцүүлэг, судалгааны багуудын хийсэн ажлууд орсон. Төрийн албан хаагчид болон боломжит хэрэглэгчидтэй хэлэлцүүлэг хийсэн байна.

Канадын сайн сайхан байдлын индекс(CIW) нь иргэдэд чиглэсэн санаачилга юм. Засгийн газар нь сайн сайхан байдлыг хэмжих, дэмжихэд идэвхтэй оролцдог Их Британи, Итали, Франц, Герман, Австрали, Бутан зэрэг бусад орноос ялгаатай.

Канадын сайн сайхан байдлын индексийг тооцох үйл явц нь 2001-2010 онд гурван үе шаттай хэрэгжсэн байна. Үүнд:

- Канадчуудын амьдралын чанартай холбоотой гол домайнуудыг тодорхойлох,
- Эдгээр домэйн бүрийн сайн сайхан байдалтай шууд холбоотой үзүүлэлтүүдийг тодорхойлох, холбогдох өгөгдлийг нэгтгэх,
- Домэйн тус бүр болон нийлмэл индексийг нэгтгэх,

Канадын сайн сайхан байдлын индекс нь цаг хугацааны явцад Канадчуудын тогтвортой байдал, өөрчлөлтийг хэмждэг харилцан шүтэлцээтэй найман домэйнээс

бүрдсэн нийлмэл индекс юм. Нэг домэйнд 8 үзүүлэлтийг сонгож, нэгдсэн индекс тооцоход нийтдээ 64 үзүүлэлтийг ашиглаж байна.

Хүснэгт 2. Канадын сайн сайхан байдлын индексийн үзүүлэлтүүд

Хүрээ	Хэмжээс	Үзүүлэлт
Нийгмийн амьдрах чадвар	Нийгмийн аюулгүй байдал	Гэмт хэргийн ноцтой байдлын индекс
Ардчилал	Оролцоо	Сонгуульд сонгогчдын ирцийн хувь
		Бүртгэгдсэн, сонгуулийн эрх бүхий сонгогчдын харьцаа
		Хууль, өмгөөлөл, улс төрийн бүлэглэлд сайн дураараа оролцдог хүн амын эзлэх хувь
		Ахмад, залуу сонгогчдын оролцооны зөрүү, хувиар
	Манлайлал	Парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь
Боловсрол	Боловсролын анхан шатны мэдлэг, ур чадвар	Хүүхэд асрах төвд явж байгаа 0-5 настай хүүхдийн эзлэх хувь
		Улсын сургуулийн багш сурагчдын харьцаа
	Эрдэм шинжилгээний нийт ололт амжилт, түвшин, ба оролцоо	Улсын сургуулийн нэг оюутанд ногдох дундаж зардал
		Бакалаврын жилийн дундаж сургалтын төлбөр
		Ахлах сургуулиа төгссөн, ажиллах хүчээр ажилладаг Канадын 20-24 насныхны эзлэх хувь
Дээд боловсролтой хүн амын 25-64 насны залуучуудын эзлэх хувь		
Байгаль орчин	Агаар	Хүлэмжийн хий (megatonnes of CO2 per year)
	Эрчим хүч	Эрчим хүчний анхдагч бүтээгдэхүүн (terajoules)
		Оршин суугчдын эрчим хүчний ашиглалт (petajoules per 1,000 households)
	Цэвэр ус	Жилд ашиглах усны хэмжээ Canada (km3)
	Сэргээгдэхгүй материал	Металлын нөөцийн индекс
Биологийн нөөц	Нийт газар тариалангийн газар (hectares)	
Эрүүл мэнд	Дундаж наслалт/нас баралт	Төрөх үеийн дундаж наслалт
	Биеийн эрүүл мэндийн байдал	Чихрийн шижинтэй хүн амын эзлэх хувь
	Хөдөлгөөний эрүүл мэнд	Эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар чөлөө авсан хүний эзлэх хувь
	Нийтийн эрүүл мэнд	Өнгөрсөн онд томуугийн эсрэг дархлаажуулалтанд хамрагдсан хүн амын эзлэх хувь
	Эрүүл мэндийн үйлчилгээ	Ердийн эмнэлгийн эмчтэй Канадчуудын эзлэх хувь
Амьжиргааны түвшин	Дундаж болон медиан орлого, хөрөнгө	Гэр бүлийн татварын дараах дундаж орлого
	Орлого баялгийн хуваарилалт	Жини коэффициент (орлогын ялгаа)
	Эдийн засгийн аюулгүй байдал	Бага орлоготой хүмүүсийн эзлэх хувь
		Хүнсний аюулгүй байдал дунд зэрэг эсвэл хүнд байдаг Өрхийн эзлэх хувь
		Ажиллаж буй ажиллах хүчний эзлэх хувь

		Урт хугацааны ажилгүйдлийн үеийн ажиллах хүчний эзлэх хувь
Цаг ашиглалт	Цаг хугацаа	25-64 насны Канадчуудын долоо хоногт үндсэн ажил дээрээ 50-аас дээш цагаар ажилладаг хүмүүсийн эзлэх хувь
		долоо хоногт 30-аас доош цагийн ажиллах хүчний ажиллах хүчний эзлэх хувь
		Цалин хөлсөөр ажилладаг хүмүүсийн ажлын өдрийн ажлын дундаж хугацаа
	Хугацааны сонголт	Уян хатан цагаар цалин хөлстэй ажилладаг иргэдийн хувь хэмжээ
		Ердийн, ажлын өдрийн ажлын цагтай ажиллах хүчний хувь
	Түр зуурын байдал	7-9 цаг чанартай унтаж амардаг хүний эзлэх хувь

Эх сурвалж: <https://uwaterloo.ca/canadian-index-wellbeing/what-we-do/domains-and-indicators>

Бусад улсуудын туршлага

2009 онд гарсан Стиглиц-Сен-Фитусси Комиссын тайлангаас хойш статистикийн байгууллагуудын дунд олон санаачлага гарсан. Австри, Бельги, Эквадор Финлянд, Герман, Итали, Израиль, Япон, Люксембург, Нидерланд, Шотланд, Их Британи улсуудад хэрэгжүүлж буй санаачилгын нэгтгэлийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 3. Улс орнуудын сайн сайхан байдлын индекхийн үзүүлэлтүүд

Улс	Санаачилга	Хариуцан гаргадаг байгууллага	Тайлбар
Австри	Австри ямар байна?	Австрийн статистик	Австрийн статистикийн байгууллагаас 2010 оноос эхлэн жил бүр материаллаг баялаг, амьдралын чанар, байгаль орчны тогтвортой байдал гэсэн гурван хэмжигдэхүүнээр ангилсан 30 үндсэн үзүүлэлтийг гаргасан. Интерактив хэрэгслийг ашиглан хэрэглэгчид түүхэн чиг хандлагыг судлах, үзүүлэлтүүдийг харьцуулах боломжтой
Бельги	ДНБ-ий нэмэлт үзүүлэлтүүд	Үндэсний тооцооны институт	2014 онд батлагдсан хуулийн дагуу Холбооны түвшинд хүмүүсийн сайн сайхан байдал, нийгмийн хөгжлийг хэмжихэд чиглэсэн ДНБ-ийг нөхөх үзүүлэлтүүдээр жил бүр Үндэсний тооцооны институтээс тайлан гаргахыг заасан. Тайланг 2016, 2017 онд гаргасан ба одоо үе (энд ба одоо), ирээдүйн үе (дараа нь) болон бусад улс орнууд (өөр газар) гэсэн гурван хэмжигдэхүүнийг хамарсан 13 сэдвээр бүлэглэн 67 үзүүлэлтийн чиг хандлагыг гаргасан.

Эквадор	Сайхан амьдрах	Эквадорын статистикийн байгууллага	Сайхан амьдрах санаачилгыг илүү өргөн хүрээнд дэмжиж Эквадорын Статистикийн газар (INEC) ахиц дэвшлийг хянах багц үзүүлэлтийг нэгтгэсэн.
Финлянд	Финдикатор	Финландын статистик болон Ерөнхий сайдын алба	Финлянд улсын Ерөнхий сайдын алба, Финландын Статистикийн газраас 2009 онд гаргасан Findicator нь нийгмийн хөгжил дэвшлийн 100 гаруй үзүүлэлтийг багтаасан онлайн эмхэтгэл юм. Сайн сайхан байдлын үзүүлэлтүүдийн тодорхой ангилалд найман хэмжээсийн 23 үзүүлэлтийг багтаасан
Герман	Германы сайхан амьдрал	Холбооны Засгийн газар	Герман дахь сайн сайхан байдлын өнөөгийн байдал, чиг хандлагыг хэмжих 46 үзүүлэлтийг 12 хэмжээст багтаасан болно. Шалгуур үзүүлэлтүүдийг тогтмол шинэчилж байна.
Итали	Тэгш, тогтвортой сайн сайхан байдлын хэмжүүрүүд	Эдийн засаг, хөдөлмөрийн үндэсний зөвлөл (CNEL) ба Үндэсний статистикийн хүрээлэн (ISTAT)	Тэнцвэртэй, тогтвортой сайн сайхан байдал (BES) санаачилга нь Италийн Ерөнхий сайдын зарлан хуралдуулсан хорооны зөвлөмжийг үндэслэн сайн сайхан байдлын хүрээг бий болгоход хүргэсэн бөгөөд үүнийг Италийн статистикийн газрын олон үзүүлэлт, жилийн тайлангаар хянадаг. 2016 онд батлагдсан хуулиар төсвийн хэлэлцүүлгийн хүрээнд парламентад тайлагнах илүү нарийвчилсан хүрээг боловсруулна гэж заасан.
Израил	Сайн сайхан байдал, тогтвортой байдал ба үндэсний уян хатан байдлын үзүүлэлтүүд	Статистикийн төв товчоо	2015 оны 4-р сард батлагдсан Засгийн газрын тогтоолоор Статистикийн төв товчооноос сайн сайхан байдал, тогтвортой байдал, үндэсний уян хатан байдлын олон үзүүлэлтийг нийтлэхийг хүссэн. 2015 оны тогтоолоор 10 хүрээний үзүүлэлтүүдийг багтаасан болно (ажлын чанар; хувийн аюулгүй байдал; эрүүл мэнд; орон сууц, дэд бүтэц; боловсрол; дээд боловсрол, ур чадвар; хувийн ба нийгмийн сайн сайхан байдал; хүрээлэн буй орчин; иргэний оролцоо ба засаглал; амьдралын материаллаг түвшин) ба нэмэлт хоёр салбарт (мэдээллийн технологи; ба чөлөөт цаг, соёл, олон нийт) үзүүлэлтүүдийг хөгжүүлэхийг уриалав. Хүрээ тус бүрт 8 үзүүлэлтийг сонгосон
Япон	Сайн сайхан байдлыг хэмжих комисс	Засгийн газрын захиалгаар	Засгийн газрын “Шинэ өсөлтийн стратеги”-ын хүрээнд Шинэ өсөлт, сайн сайхан байдлын талаарх судалгаа, судалгааг сурталчлах, эдгээр салбарын статистикийг боловсронгуй болгох зорилгоор Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяанд, мэргэжилтнүүдийн

			оролцоотойгоор Сайн сайхан байдлыг хэмжих комисс 2010 онд байгуулагдсан. 2011 оны 12-р сард тус комиссоос "Үндэсний сайн сайхан байдлыг хэмжих - Сайн сайхан байдлын талаарх дэвшүүлсэн үзүүлэлтүүд"-г гаргасан бөгөөд уг тайланд (нийгэм, эдийн засгийн гурван нөхцөл байдал, эрүүл мэнд, хамаатан садны үндсэн дээр суурилсан) субъектив болон бодит үзүүлэлтүүдийг багтаасан
Люксембург	Сайн сайхан байдал ба ДНБ / Люксембургийн сайн сайхан байдлын индекс	Статек (Үндэсний статистик, эдийн засгийн судалгааны хүрээлэн), Эдийн засаг, нийгмийн зөвлөл, Тогтвортой хөгжлийн дээд зөвлөл	Люксембургийн сайн сайхан байдлын индексийг ("PIBien-être") Үндэсний статистик, эдийн засгийн судалгааны хүрээлэн (Статек), Эдийн засаг, нийгмийн зөвлөл, Тогтвортой хөгжлийн дээд зөвлөлийн хамтын ажиллагааны хүрээнд боловсруулсан. Тус тайланд ЭЗХАХБ-ын сайн сайхан байдлыг хэмжих хүрээтэй нягт уялдсан 11 салбарт бүлэглэгдсэн 63 үзүүлэлтийг багтаасан. Нэмэлтээр эдгээр үзүүлэлтийг синтетик индексээр нэгтгэн дүгнэсэн. Энэ нь хэрэглэгчдийг өгөгдлөөр дамжуулан удирдан чиглүүлэх "луужин" болж өгөх бөгөөд 2009 оноос хойш нийт сайн сайхан байдлын чиг хандлага, мөн тодорхой домэйнүүдийн чиг хандлагыг үнэлэхэд 2017 оны тайланд ашигласан болно.
Нидерланд	Сайн сайхан байдлыг хянах	Статистикийн төв товчоо	2017 онд Засгийн газрын хуралдаанаас Нидерландын Статистик (CBS) -д олон нийтийн болон улс төрийн мэтгэлцээнийг хөнгөвчлөх зорилгоор "Сайн сайхан байдлын хяналт"-ыг жил бүр эмхэтгэн гаргахыг даалгасан. Бодлогын үнэлгээний агентлагууд - Нидерландын Эдийн засгийн бодлогын шинжилгээний товчоо (CPB), Нидерландын Байгаль орчны үнэлгээний газар (PBL), Нидерландын Нийгмийн судалгааны хүрээлэн (SCP)-г хамтран сайн сайхан байдалд суурилсан судалгааг тогтмол хийлгэхээр шийдвэрлэсэн. Хяналт нь 2011 оноос хойш "Тогтвортой байдлын хяналт" -ыг үндэслэн (амьдралын чанар энд ба одоо; ирээдүйн нөөц; бусад улс орнуудад үзүүлэх нөлөө) гэсэн 3 хүрээнд нийт есөн хэмжүүрээр гаргасан.

Шотланд	Шотланд гүйцэтгэл/ Үндэсний Гүйцэтгэлийн суурь	Шотландын засгийн газар	Шотландын засгийн газрын Үндэсний Гүйцэтгэлийн Хүрээг (NPF) анх 2007 оны зарцуулалтыг хянах ажлын хүрээнд гаргасан бөгөөд Шотландын талаарх 10 жилийн алсын хараа, засгийн газрын ололт амжилтыг хэмжих үр дүнд суурилсан аргачлалыг ашигладаг. Үүнд 5 стратегийн зорилт, үндэсний 16 үр дүн, үндэсний 55 үзүүлэлт багтсан. NPF нь төрийн үйлчилгээ үзүүлэх байгууллагуудтай байгуулсан үр дүнгийн гэрээний үндэс суурийг бүрдүүлдэг бөгөөд тэдгээрийн үр дүнтэй байдлыг хянахад ашигладаг.
Их Британи	Үндэсний сайн сайхан байдлыг хэмжих (MNW) хөтөлбөр	Их Британийн Үндэсний статистикийн газар	Тус хөтөлбөр нь 2010 онд эхэлсэн бөгөөд сайн сайхан байдлын хэмжүүрээр дамжуулан "Их Британи бүхэлдээ хэрхэн аж төрж байгааг" хянах, тайлагнах зорилготой юм. Ажлын явцын тайланг эрүүл мэнд, байгалийн орчин, хувийн санхүү, гэмт хэрэг зэрэг салбарыг хамарч, хоёр жилд нэг удаа гаргадаг. Энэхүү арга хэмжээ нь бодит болон субъектив өгөгдлийг агуулдаг.

Эх сурвалж: Beyond GDP, Measuring What counts for Economic and Social Performance, OECD

Дэлхийн хэмжээний томоохон санаачилга

Улс үндэстнүүдийн санаачилгаас гадна дэлхийн хэмжээнд хэд хэдэн судалгааны сүлжээнүүд бий болсон байна.


Нийгмийн хөгжлийн индекс –Social progress index

Social Progress Imperative нь Вашингтон хотод байрладаг олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллага бөгөөд шийдвэр гаргагчид болон хувь хүмүүст нийгмийнхээ болон хүрээлэн буй орчны эрүүл мэндийн талаарх хамгийн сайн мэдээллийг өгч, нийгмийн дэвшлийг түргэтгэх үйл ажиллагааг нэн тэргүүнд тавихад нь тусалдаг байна.

Нийгмийн хөгжлийн индекс (SPI) нь эдийн засгийн хүчин зүйлээс илүүтэйгээр нийгэм, хүрээлэн буй орчны үр дүнг шууд ажиглах замаар нийгмийн сайн сайхан байдлыг хэмждэг. Нийгмийн болон хүрээлэн буй орчны хүчин зүйлүүдэд эрүүл мэнд (эрүүл мэнд, орон байр, эрүүл ахуй зэрэг), тэгш байдал, тогтвортой байдал, хувийн эрх чөлөө, аюулгүй байдал орно.

Хүний үндсэн хэрэгцээ, сайн сайхан байдлын үндэс суурь, хөгжил дэвшлийн боломжийн чиглэлээрх 54 үзүүлэлтээр улс орнуудыг харьцуулан харуулж байна.

Зураг 2. Нийгмийн хөгжлийн индекс тооцох үзүүлэлтийн хүрээ



Эх сурвалж. 2020 Social progress index, Executive Summary

2010 онд хэсэг эрдэмтэн судлаачид болон бизнесийн удирдагчид уулзалдаж улс орны хөгжлийн түвшинг илүү сайн хэмжих хэмжүүр боловсруулж, цаашлаад хөгжлийн тэргүүлэх чиглэлийг илүү сайн ойлгохыг эрэлхийлсэн. Түүний дараа Харвардын Бизнесийн сургуулийн профессор Майкл Портер, Массачусетсийн Технологийн Их Сургуулийн профессор Скотт Стерн нарын удирдлага дор АНУ-д төвтэй Social Progress Imperative хэмээх ашгийн бус байгууллагыг байгуулж, 2013 онд нийгмийн хөгжлийн индексийн бета хувилбарыг 50 улсын нийгэм, хүрээлэн буй орчны мэдээлэлд үндэслэн боловсруулсан байна. 2013 оны 7-р сарын 11-ний өдөр Social Progress Imperative-ийн дарга, Харвардын Бизнесийн сургуулийн профессор Майкл Портер НҮБ-ын Хөгжлийн сайд нарын 6-р форумд үг хэлж, Нийгмийн дэвшлийн индексийн талаар хэлэлцүүлсэн. Нийгмийн дэвшлийн индексийг 133 орныг хамруулан тооцож 2015 онд хоёр дахь хувилбараа гаргасан байна.

Глобал нийгмийн хөгжлийн индексээс гадна түүнийг бий болгоход ашигласан аргачлалыг Бразилийн Амазоны бүс зэрэг жижиг газар нутагт нийгэм, байгаль орчны гүйцэтгэлийг хэмжихэд тохируулан боловсруулсан. Мөн Парагвайн үндэсний засгийн газар ДНБ-ий тооцоололтой зэрэгцүүлэн Нийгмийн хөгжлийн индексийн гүйцэтгэлийг тодорхойлж байна. Европын Комисс нь Европын Холбооны нийгмийн дэвшлийн индексийг бий болгохын тулд Social Progress Imperative-тэй хамтран ажилласан бөгөөд ЕХ-ны нийгмийн дэвшлийн индексийг 2016 оны 10-р сард нийтэлсэн байна.

Википрогресс - дэлхийн томоохон интернэт платформ

Википрогресс бол ЭЗХАХБ-аас зохион байгуулдаг "Нийгмийн дэвшлийг хэмжих нь" сэдэвт Глобал төслийн албан ёсны платформ юм.

Википрогрессийн зорилго нь ахиц дэвшлийн шинэ, илүү ухаалаг арга хэмжээ авахыг хүссэн байгууллага, хувь хүмүүсийн хамтын ажиллагааны дэмжлэгтэйгээр глобал мэдээллийн хэрэгслийг бий болгох явдал юм.

Википрогресс нь 2009 онд БНСУ-ын Пусан хотод болсон ЭЗХАХБ-ын Дэлхийн статистикийн форумд бета хувилбараар танилцуулсан байна.

Википрогресс платформ нь wikichild буюу хүүхдийн сайн сайхны төлөө зориулагдсан викиг байрлуулдаг. Хүүхдийн сайн сайхан байдлыг нийгмийн ирээдүйн сайн сайхан байдлын чухал хэсэг гэж үзэж болно. Тэдний сайн сайхан байдал нь манай нийгмийн тогтвортой байдлын түлхүүр юм.

ЭЗХАХБ Илүү сайхан амьдралын индекс -‘OECD Better Life Index’

ЭЗХАХБ (OECD) нь олон жилийн турш хүмүүсийн сайн сайхан байдал, нийгмийн хөгжил дэвшилд анхаарлаа хандуулж, зөвхөн эдийн засгийн тогтолцооны үйл ажиллагааг төдийгүй хүмүүс, өрхүүдийн амьдралын нөхцөл байдлыг судалж ирсэн.

Бидний амьдрал сайжирч байна уу? Бодлогууд бидний амьдралыг хэрхэн сайжруулах вэ? Бид зөв зүйлийг хэмжиж байна уу? ЭЗХАХБ-аас гаргасан Илүү сайн амьдрах санаачилга (Better Life Index)-ын ажлын хөтөлбөр эдгээр асуултанд хариулдаг. Энэ нь хувь хүмүүс, улс үндэстнүүдийн сайн сайхан байдлыг өдөөж, бүх хүмүүст илүү их ахиц дэвшил гаргахын тулд юу хийх хэрэгтэйг ойлгох боломжийг олгодог.

ЭЗХАХБ нь сайн сайхан байдлын хэмжүүрийг хөгжүүлэх зорилго бүхий томоохон хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд одоо байгаа сайн сайхан байдлын хэмжүүр ба бодлогын оролцооны хоорондын ялгааг арилгах зорилгоор дүн шинжилгээ хийж байна.


Сүүлийн жилүүдэд ДНБ зэрэг макро эдийн засгийн статистик мэдээлэл нь энгийн хүмүүсийн амьжиргааны нөхцлийг хангалттай нарийвчлан харуулдаггүйтэй холбоотой асуудал гарч ирсэн. Арван жилийн эхэн үеийг тодорхойлсон хүчтэй өсөлт, эдийн засгийн сайн үзүүлэлттэй жилүүдэд эдгээр санаа зовоосон асуудлууд байсаар байсан бол санхүү, эдийн засгийн хямрал энэ асуудлыг улам бүр нэмэгдүүлсэн байна.

Эдгээр ойлголтыг шийдвэрлэх нь төрийн бодлогын итгэл үнэмшил, хариуцлагатай байдлыг хангахад төдийгүй ардчиллын үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой юм.

Нийгмийн хөгжил дэвшил нь хүмүүс, өрхүүдийн сайн сайхан байдлыг дээшлүүлэх явдал юм. Ийм ахиц дэвшлийг үнэлэхийн тулд зөвхөн эдийн засгийн тогтолцооны үйл ажиллагааг төдийгүй хүмүүсийн янз бүрийн туршлага, амьдралын нөхцөл байдлыг харах хэрэгтэй гэж үзсэн.

Эдийн засгийн гүйцэтгэл, нийгмийн дэвшлийг хэмжих комиссоос 2009 онд гаргасан зөвлөмжид үндэслэн сайн сайхан байдал, хөгжил дэвшлийг хэмжих хүрээг боловсруулсан байна. Энэхүү хүрээ нь одоогийн сайн сайхан байдал, сайн сайхан байдлын үр дүнгийн тэгш бус байдал, ирээдүйн сайн сайхан байдлын нөөц гэсэн гурван ялгаатай бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.

Зураг 3. Илүү сайхан амьдралын индекс тооцох үзүүлэлтийн хүрээ



Эх сурвалж: <https://www.oecd.org/statistics/measuring-well-being-and-progress.htm>

Гурав. Манай улсад хөгжлийн индексийн үзүүлэлтийг тооцсон байдал

Манай улсын хувьд орон нутаг болон нийслэлийн түвшинд дараах индексүүдийг тооцож байсан байна.

Монгол Улсын хүний хөгжлийн индекс

НҮБ-аас эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжилд хүний хөгжил улам бүр чухал болж байгааг тодорхойлох зорилгоор үндэсний хүний хөгжлийн илтгэлийг гаргаж байхыг гишүүн орнууддаа уриалан, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ) 1990 онд дэлхийн хүний хөгжлийн анхны илтгэлийг боловсруулсан. Монгол Улс 1997 оноос хойш 3 жилийн давтамжтайгаар нийт 6 илтгэлийг бэлтгэж тархаасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд хүн бүрийг эрүүл саруул аж төрөх, урт наслах, амар тайван байх, түүх соёлоо хүндлэх, бүтээлчээр ажиллах, байнга суралцах оюун ухаан, авьяас чадвараа нээн хөгжүүлэх сонголттой байх таатай орчныг бүрдүүлэн "Монгол хүний амьдралын чанар"-ыг тасралтгүй дээшлүүлж, 2015 он гэхэд Мянганы хөгжлийн зорилтуудыг бүрэн биелүүлж, хүний хөгжлийн индексийг 0.83-д хүргэх бодлого баримталсан байдаг. Энэ хөтөлбөр 2015 онд дуусгавар болж дараагийн буюу "Тогтвортой хөгжлийн зорилго" болж, 17 зорилго 169 зорилтыг баталж үргэлжлүүлэн 2016 оноос албан ёсоор хэрэгжиж эхэлсэн. УИХ -ын 2020 оны 05 дугаар сарын 13 өдрийн 52

дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталж, хүний хөгжлийн индексийг 2025 онд 0.77, 2030 онд 0.85, 2050 онд 0.9-д хүргэхээр зорилт тавьсан байна. Монгол Улсын хүний хөгжлийн индекс 2019 онд 0.74 болж, 2011 оноос 4.9 хувиар өссөн үзүүлэлтэй байна⁶.

Нэгдсэн түрүүлэгч үзүүлэлтүүд

Манай улсын хувьд нэгдсэн түрүүлэгч үзүүлэлтийг анх МУИС-ийн багш Б.Эрдэнэбат (2012) нийт 51 хувьсагч ашиглан ЭЗХАХБ-ын аргачлалтай төстэй байдлаар тооцсон байна. Түүний боловсруулсан Microsoft Excel-д суурилсан загварыг ашиглан Сангийн Яамнаас энэхүү үзүүлэлтийг 2016-2018 онуудад сарын тоон мэдээлэлд суурилан шинэчлэх байдлаар улирал бүр олон нийтэд зарлаж байв. Нэгдсэн Түрүүлэгч Индикатор нь эдийн засаг ойрын ирээдүйд ерөнхий чиг хандлагатай харьцуулахад хэрхэн өөрчлөгдөхийг таамаглах зорилготой хийгдэж байсан.

Орон нутгийн хөгжлийн индекс

Орон нутгийн хөгжлийн ерөнхий түвшинг тодорхойлох, төсвийн хөрөнгө оруулалтыг аймаг, орон нутгийн хөгжлийн бодит түвшинд тулгуурлан оновчтой төлөвлөх зорилгоор “Орон нутгийн хөгжлийн индекс тооцох аргачлал”-ыг МУ-ын Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 20 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна.

Энэ индексийг сум, аймаг, бүсийн хөгжлийн ерөнхий түвшинг үнэлэх, сум, аймаг, бүсийн хөгжилд чиглэсэн бодлого боловсруулах, Засгийн газраас сум, аймаг, бүсийг хөгжүүлэхээр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнг үнэлэх, хэмжихэд ашиглаж байна.

Сумын хөгжлийн индекс тооцох үзүүлэлт нь орон нутгийн хөгжлийн индексийг тооцох суурь үзүүлэлт болж байна. Аймгийн хөгжлийн индексийг харьяалах сумдын үзүүлэлт тус бүрийн индексийн энгийн дундаж утгаар тооцож байна.

Сумын хөгжлийн индекс

Засгийн газрын 2014 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 242 дугаар тогтоолоор “Сумын хөгжлийн индекс тооцох аргачлал” –ыг батлан хэрэгжүүлж байсан бөгөөд 2018 онд орон нутгийн хөгжлийн индекс тооцох аргачлал батлагдсантай холбоотойгоор энэ аргачлалыг хүчингүй болгосон байна. 2018 онд баталсан шинэчилсэн аргачлалын дагуу сумын хөгжлийн түвшинг боловсрол, эрүүл мэнд, эдийн засаг бизнес, нийгмийн бусад үзүүлэлт, дэд бүтэц, байгаль орчин гэсэн 6 бүлгийн 33 үзүүлэлтийг ашиглан тооцож байна.

Нийслэлийн эрүүл аюулгүй байдлын индекс болон Аз жаргалтай хотын индекс

Нийслэлийн эрүүл, аюулгүй байдлын индекс (НЭАБИ) нь Монгол Улсын Нийслэлийн оршин суугч иргэдийн эрүүл, аюулгүй, ээлтэй орчинд амьдрах нөхцлийг бүх талаар бүрдүүлэхэд дүүрэг, хороо, иргэд, олон нийтийн зүгээс эрүүл, аюулгүй байдлыг хэрхэн хангаж буйг илэрхийлэх нэгдсэн үзүүлэлт юм. Энэ индексийг тооцох аргачлалыг боловсруулахдаа Монгол Улсын Засгийн газрын 2010 оны “Хөгжлийн индекс (ХИ) тооцох тухай” 88 дугаар тогтоолыг ашиглан ерөнхий зарчим, үзүүлэлтийн тодорхойлолт, арга зүйд үндэслэсэн боловсруулсан бөгөөд 2015 онд

⁶ ҮСХ, Хүний хөгжил -2019 танилцуулга

ҮСХ-ны даргын А/160 тоот тушаалаар баталсан байна.. Нийслэлийн эрүүл, аюулгүй байдлын индексийг 7 бүлэг, 29 шалгуур үзүүлэлтийн дагуу тооцож, Нийслэлийн хэмжээнд эрүүл, аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн бодлого боловсруулах, шийдвэр гаргахад үндсэн баримт бичиг болгон ашиглаж байсан..

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт иргэд, оршин суугчдаа дээдэлсэн, тэдний амьдрах эрүүл аюулгүй, тав тухтай орчныг хангасан “Аз жаргалтай хот” болгох зорилт дэвшүүлсэн. Энэхүү зорилтын хүрээнд “Хотын хөгжлийн индекс тооцох аргачлал”-ыг шинэчлэн боловсруулж Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны А/77 дугаар тушаалаар батлан ашиглаж байна.

Дөрөв. Нийгэм, эдийн засгийн хөгжлийг хэмжих үзүүлэлт, тэдгээрийн чиг хандлага

Дэлхий дахинд хөгжлийн түвшинг зөвхөн эдийн засгийн өсөлтөөр хэмждэг хандлагаас зайлсхийж, нийгмийн хөгжлийг илэрхийлэх бусад үзүүлэлтүүдээр хэмжих асуудалд онцгой анхаарч байна.

НҮБ-аас 2015 онд батлан гаргасан Дэлхийн хөгжлийг хэмжих ТХЗ-ийн 169 бодлогын зорилт түүнийг хэмжих 244 үзүүлэлт нь үндэсний түвшний хөгжлийг хэмжихэд хэтэрхий их байгаа бөгөөд улс орнууд хөгжлийнхөө тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, тэдгээрийн түвшинг чанартай цөөн үзүүлэлтээр тодорхойлохыг ЭЗХАХБ-аас гаргасан *“Beyond GDP Measuring What Counts for Economic and Social Performance”* номонд онцолсон байна.

Хүний ажиллаж, амьдрах таатай орчин нөхцлийг бүрдүүлэх явдал нь Засгийн газрын үндсэн зорилго байдаг бөгөөд нийгмийн бүлгүүд, хувийн хэвшлийн байгууллагууд ч мөн адил энэ зорилгын төлөө ажиллаж ёстой.

Хүний амьдрах таатай нөхцөл гэдэгт хүний эрүүл мэнд, боловсрол, гэр бүл, нийгмийн бүлэг, орон байр, ажиллах орчин зэрэг маш олон зүйл нөлөөлж байдаг.

Эдгээр олон хүчин зүйлүүдийн нөлөөллийг хэмжихдээ дээрх хүчин зүйлүүдийг **нийгэм, эдийн засаг, байгаль орчин** гэсэн 3 үндсэн домэйнд хуваан авч үзэж байна.

Манай улсын хувьд эдгээр домайнд харгалзах зарим үзүүлэлтийг сонгон авч хандлагыг тодорхойллоо.

Нийгмийн хөгжлийг хэмжих үзүүлэлт


Улс үндэстний гол баялаг, хөгжлийн хүч, ирээдүйг тодорхойлогч үнэт зүйл бол хүн өөрөө байдаг. Хүний үйл ажиллагааг идэвхжүүлдэг гол хөдөлгөгч хүч нь эрүүл мэнд, амьдрах орчин нөхцөл болон амьдралын чанараа сайжруулах гэсэн хүсэл зорилго юм.⁷

⁷ ҮСХ, Хүний хөгжлийн илтгэл-2019

Эрүүл мэнд

Хүмүүс урт удаан наслах, өвчин зовлон, хөгжлийн бэрхшээлээс ангид байх нь эрүүл мэндийн зардлыг бууруулж нийгэмд үр өгөөжөө өгдөг.

Зураг 4. Хүн амын өсөлт ба дундаж наслалт



Манай улсын хүн ам 2014 он хүртэл өсөж байсан бол 2015 оноос өсөлтийн хурд саарсан байна.

Дундаж наслалт 2010 онд 68.05 байсан бол 2019 онд 70.41 болж бүтэн 2 жилээр өссөн байна. Энэ нь хүн амын амьдрах нөхцөл тодорхой хэмжээгээр дээшилж байгааг харуулж байна.

Боловсрол

Боловсрол нь хүмүүсийн амьдралын түвшинг дээшлүүлэх, мэдлэг, ур чадварыг хөгжүүлэхэд тусалдаг. Хувь хүмүүсийн хувьд боловсрол нь өндөр цалинтай ажил мэргэжил, илүү сайн сайхан амьдралд хүргэх гол хүчин зүйл гэж үздэг. Харин улс үндэстний хувьд чадварлаг хүний нөөцтэй байх нь эдийн засгийн хөгжил, амьдралын нөхцөлийн сайжруулалтад туслах чухал үүрэг гүйцэтгэдэг.

Их дээд сургууль төгсөгчдийн тоо 2010 онд 35.8 мянга байсан бол 2019 онд 28.0 мянга болж 21.8 хувиар буурсан байна. Харин техникийн болон мэргэжлийн боловсролын байгууллага төгсөгчдийн тоо 2010 онд 11.2 мянга байсан бол 2019 онд 18.9 мянга болж 68.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 4. 15-24 насны хүн амд ИДС болон техникийн болон мэргэжлийн боловсролын байгууллага төгсөгчдийн эзлэх хувь

он	ИДС төгсөгчид, мян хүн	Техникийн болон мэргэжлийн боловсролын байгууллага төгсөгчид, мян хүн	15-24 насны хүн амд ИДС, Техникийн болон мэргэжлийн боловсролын байгууллага төгсөгчдийн эзлэх хувь
2010	35.8	11.2	8.1
2011	37.7	23.1	10.6
2012	37.2	23.4	10.8
2013	33.9	18.4	9.5
2014	35.2	19.0	10.4
2015	35.9	19.5	10.9
2015	34.7	19.5	11.0
2017	29.2	20.5	10.4
2018	23.0	21.2	9.3
2019	28.0	18.9	10.1


ИДС, Техникийн болон мэргэжлийн боловсролын байгууллага төгсөгчдийн 15-24 насны хүн амд эзлэх хувь харьцангуй тогтвортой 8.1-11.0 хувийн хооронд хэлбэлзэж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтаас гаргасан 2015/2016 оны хичээлийн жилд их дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага төгсөгчдийн дунд 4 жил дараалан мөшгих судалгаа хийсэн байна. Уг судалгааны 2020 оны тайланд төгсөгчдийн 74.8 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа бол 4.5 хувь нь ажилгүй, харин 20.7 хувь нь ямар нэг шалтгааны улмаас ажил хийгээгүйг онцолсон байна. Манай улсын хөгжлийн зорилт бол аль болох олон хүнийг ажил мэргэжилтэй болгож, тэдгээрийг ажлын байраар хангах асуудал юм.

Цалинтай ажил

Цалинтай ажил нь хүмүүсийн хувьд өөртөө болон гэр бүл, хамаатан садандаа өдөр тутмын болон урт хугацааны санхүүгийн хэрэгцээгээ хангахад шаардагдах эдийн засгийн эх үүсвэрийг олж авах хэрэгсэл юм. Мөн түүнчлэн цалинтай ажил эрхлэх нь тухайн хүн өөрийгөө тодорхойлох, үнэлэх үнэлэмжид нь нөлөөлдөг. Цалинтай ажил эрхлэх нь эдийн засгийн өсөлт, хөгжлийг дэмжиж өгдөг.

Зураг 5. Цалинтай ажиллагчидын хөдөлмөрийн насны хүн амд эзлэх хувь



Манай улсын хөдөлмөрийн насны хүн амын 54-60 хувь нь цалин хөлстэй ажил эрхэлж байна. Энэ үзүүлэлт өндөр байх нь бидний амьдралын түвшин сайжирч байгааг харуулна.

Ажилгүйдэл


Ажилгүйдэл нь эдийн засаг, нийгмийн аль алинд нь хамааралтай. Ажилгүй байх нь хувь хүмүүс болон тэдний гэр бүлийн санхүүгийн болон сэтгэл зүйн байдалд сөргөөр нөлөөлдөг.

Ажилгүйдлийн түвшин нь эдийн засагт хөдөлмөрийн ашиглагдаагүй нөөцийн хэмжээг илэрхийлэх бөгөөд эдийн засгийн мөчлөгт мэдрэмтгий байдаг.

Ажилгүйдлийн түвшин нь эдийн засгийн уналтын үед хурдацтай өсөж, эдийн засаг сэргэх үед аажмаар буурах зүй тогтолтой байдаг.

Зураг 6. Эдийн засгийн өсөлт ба ажилгүйдлийн түвшин

Ажилгүйдлийн түвшин сүүлийн 10 жилд харьцангуй тогтвортой буюу 7.5-10.0 хувьтай байна. Харин бодит эдийн засгийн өсөлт 2011 онд хамгийн өндөр буюу 17.3 хувь байсан бол өнгөрсөн онд -5.3 хувь болон агшжээ. Эндээс харахад Манай улсын хувьд дээрх зүй тогтол төдийлөн хангагдахгүй байна.



Эдийн засгийн өсөлт ба ажилгүйдлийн түвшний зүй тогтол нь тухайн улсын эдийн засгийн бүтэц, онцлог, хөгжлийн түвшин зэргээс хамаарч хүчтэй болон сул байж болно.

Манай орны хувьд сул хамааралтай байна. Учир нь манай улсын эдийн засгийн голлох салбар нь уул уурхайн салбар бөгөөд нийт ажилчдын 5 орчим хувийг эзэлж байна. Нөгөө талаар уул уурхайн салбарын өсөлт нь дэлхийн зах зээлийн үнээс шууд хамааралтай тул энэ салбарт ажилчдын тооны өөрчлөлт салбарын өсөлт бууралтад төдийлөн нөлөөлөхгүй байна.


Харин ХАА-н салбарт нийт ажиллагчдын 25 орчим хувь нь ажиллаж байна. Эдгээрийн ихэнх нь МАА-н салбарт ажилладаг бөгөөд тэдгээр ажилчид (малчид)-ийн тоо нь эдийн засгийн өсөлт/бууралтад төдийлөн өөрчлөлтгүй, тогтмол байдаг гэж үзэж болно. (Эдийн засаг өсөлттэй үед ч, бууралттай үед ч тэд мал аж ахуйгаа эрхэлж байдаг. Энэ нь манай орны онцлог нөхцөл юм.)

Гэмт хэрэг

Гэмт хэрэг нь хохирогчдын төдийгүй тэдний гэр бүл, найз нөхөд, нийгмийн сайн сайхан байдалд нөлөөлдөг юм. Гэмт хэрэгт өртсөн хүмүүс санхүүгийн болон бие махбодын, сэтгэл санааны маш их хохирол амсдаг.

Гэмт хэргээс сэргийлэх, бууруулах, засан хүмүүжүүлэх зэрэг үйл ажиллагаанд хөрөнгө их мөнгө зарцуулагддаг. Энэ нь улс орны эдийн засагт сөргөөр нөлөөлж байна.

Зураг 7. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо



Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 2018 он хүртэл өсөж байсан байна. Харин 2019 оноос буурах хандлагатай байгаа ч 2010 онтой харьцуулахад 2020 онд 16.3 хувиар өссөн байна. Энэ үзүүлэлт өсөх биш буурч байвал бид бүхний амгалан тайван амьдрах нөхцөл сайжирч байна гэж үзэж болох юм.

Гэр бүл, хамт олон

Гэр бүл, хамт олон бол нийгэм, үндэстний амьдралын үндэс суурь юм. Хүмүүсийн гэр бүл, найз нөхөд, олон нийттэй харилцах харилцаа нь эв нэгдэлтэй, хүртээмжтэй нийгмийг цогцлоох чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Гэр бүлийн халамж, туслалцаа нь хувь хүний болон иргэний нийгмийн үнэт зүйлсийн хөгжлийг дэмжихэд тусалдаг.

Хүснэгт 5. Нийт өрх, гэрлэлт, цуцлалт, мянган өрх

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Өрх	742.3	759.9	768.3	794.09	823.4	859.1	869.8	885.6	894.5	897.4
Гэрлэлт	9.3	11.9	12.8	15.8	17.3	17.6	16.8	20.5	21.0	20.0
Цуцлалт	3.1	3.2	2.5	3.5	3.8	3.9	4.0	3.9	4.2	4.3

Манай улсын нийт өрх 2010 онд 742.3 мянга байсан бол 2019 онд 879.4 мянга болж 20.8 хувиар өссөн байна

Ардчилал

Түүнчлэн нийгмийн сайн сайхан байдал нь зөвхөн иргэдийн сайн сайхан байдлаас хамаарах бус манай улс төрийн тогтолцоо шударга байдал, ардчиллын дархлаа, иргэдийн олон нийтийн амьдралд оролцох оролцоо зэрэг хүчин зүйлийг багтаасан бүхэл нийгмийн амьдралын чанараас хамаарна.

Эдийн засгийн хөгжлийг хэмжих үзүүлэлт

Үндэсний нийт орлого

ДНБ нь нэг жилийн хугацаанд тухайн улсын нутаг дэвсгэрт бий болсон нэмэгдэл өртгийн нийт дүн юм. Өөрөөр хэлбэл, харьяат болон харьяат бусын бий болгосон нэмэгдэл өртгөөс бүрдэнэ.

Үндэсний нийт орлого бол зөвхөн Монголын харьяат иргэдийн хэрэглээний бараа, үйлчилгээг худалдан авах чадавхийн үзүүлэлт юм.

ҮНО нь амьжиргааны материаллаг түвшинг тодорхойлох бөгөөд энэ үзүүлэлт өсөх нь зөвхөн одоогийн хэрэглээний чадавх нэмэгдсэн төдийгүй ирээдүйн орлогыг бүрдүүлэх, ирээдүйн хэрэглээг дэмжихэд ашиглаж болох материал баялаг (байшин, машин, санхүүгийн хөрөнгө) хуримтлуулах чадварыг нэмэгдүүлдэг. Иймд улс орны эдийн засгийн хөгжлийг хэмжихэд ҮНО-ын хэмжээг авч үздэг.

Хүснэгт 6. Нэг хүнд ногдох, ДНБ болон ҮНО, мянган төгрөг


	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
1 хүнд ногдох ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, мянган төгрөг	3 697.6	4 271.3	4 703.8	5 140.2	5 374.8	5 347.6	5 297.8	5 453.1	5 734.6	5 965.4
1 хүнд ногдох ҮНО, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, мянган төгрөг	3 275.3	3 768.6	4 176.7	4 670.6	4 800.2	4 807.1	4 803.5	4 651.5	5 104.9	5 195.1
ҮНО ба ДНБ-ий харьцаа	0.89	0.88	0.89	0.91	0.89	0.90	0.91	0.85	0.89	0.87

Манай улсын нэг хүнд ногдох ҮНО нь нэг хүнд ногдох ДНБ-ий түвшнээс доогуур байна. Тухайлбал 2010 онд Монгол улсын нутаг дэвсгэрт бий болсон нэмэгдэл өртгийн 100 төгрөг тутмын 8 төгрөг 9 мөнгө нь гадаад руу гарч байсан бол 2019 онд энэ үзүүлэлт 11 төгрөг 30 мөнгө болсон байна.

Өрхийн орлого

Өрхийн орлого нь тухайн өрхийн эдийн засгийн сайн сайхан байдлыг тодорхойлно.

Зураг 5. Өрхийн орлого, зарлага, мян төг



Өрхийн орлого, зарлагын мэдээллээс харахад 2014 он хүртэл олсон орлогоо хэрэглээндээ зарцуулдаг байсан бол 2015 оноос орлогоосоо илүүг хэрэглээндээ зарцуулж байна.

Орлогоосоо илүү хэрэглэнэ гэдэг нь ямар нэг зээлтэй байгааг харуулж байна.

Өрх өр зээлтэй биш, хэрэглээнээсээ илүү гарсан орлоготой байж түүнийгээ ирээдүйн сайн сайхны төлөө зарцуулж байгаа тохиолдолд өрхийн эдийн засгийн чадавх сайжирна гэж үзнэ.

Орон сууц

Хүний амьдрах орчин буюу орон гэр нь хүмүүсийн сайн сайхан, тав тухтай байдлын үндэс суурь юм. Орон сууц нь хүмүүсийг тайван амрах, аюулгүй байх нөхцөлөөр хангадаг. Иргэдийнхээ хэрэгцээнд нийцсэн орон сууцны хүртээмжийг сайжруулах нь

Монголчуудын амьдрал сайжирч байгаа эсэхийг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм. Манай орны хувьд гэр болон орон сууц гэсэн сууцны 2 үндсэн төрөл байдаг. Орон сууц нь гэрийг бодвол илүү тав тухтай байж болох юм. Тиймээс орон сууцанд амьдардаг өрхийн тоо нь өсөх нь улс орны хөгжилд ахиц гарч буйг илэрхийлэх боломжтой.

Хүснэгт 5. Өрхийн тоо, сууцны төрлөөр

Сууцны төрөл	2000	2010	2020
Бүгд	541.1	713.8	897.4
Гэр	275.6	322.8	342.4
Зориулалтын бус сууц	3.4	8.1	8.0
Бусад	0.8	0.1	-
Байшин	261.3	382.8	547.0
Орон сууцны байшин	119.0	152.3	264.3
Бие даасан тохилог сууц	-	3.8	6.4
Сууцны тусдаа байшин	133.9	209.9	267.9
Нийтийн байр	8.4	16.7	8.3

Хүн ам, орон сууцны тооллогын дүнгээс харахад нийт өрхөд гэрт амьдардаг өрхийн эзлэх хувь буурч, харин байшинд амьдардаг өрхийн эзлэх хувь өссөн байна. Гэрт амьдардаг өрхийн эзлэх хувь 2010 онд 50.9 хувь байсан бол 2020 онд энэ үзүүлэлт 38.2 хувь болж буурсан байна. Харин байшинд амьдардаг өрхийн эзлэх хувь 2010 онд 48.3 хувь байсан бол 2020 онд 60.9 хувь болж өссөн байна.

Улсын хэмжээнд сууцны нөхцөлийн хувьд ахиц, дэвшил гарсан байна.

Байгаль орчны хөгжлийг хэмжих үзүүлэлт

Байгаль орчин бол хүний нийгэм оршин тогтнох үндэс суурь бөгөөд бидний тогтвортой сайн сайхан байдлын эх үүсвэр юм. Манай улс нь байгалийн нөөц баялаг болон ХАА-д түшиглэсэн эдийн засагтай орон юм. Тиймээс бид байгаль орчноо хамгаалах, нөөцийг зөв зохистой ашиглах шаардлагатай байна.

Газар

Газар нутаг нь бидний сайн сайхан амьдрахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Манай орны газар нутаг нь нэг талаас байгалийн аюулт үзэгдэл, нөгөө талаас уул уурхайн үйлдвэрлэл болон мал аж ахуйн өсөлтөөс хамаарч доройтож байна.

Газрын доройтлын 56 хувь нь байгалийн үзэгдэлтэй холбоотой гэсэн судалгаа байдаг. Хэдийгээр уул уурхайн олборлолтоос үүдэн газар ихээр эвдэрч байгаа ч нөхөн сэргээлтийг хийх нь бид газраа тогтвортой ашиглах нөхцөл бүрдэнэ. Иймд нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ нь газартай холбоотой үзүүлэлт байж болох юм.

БОЭЗДС-ийн хүрээнд Газрын данс байгуулахаар ажиллаж байгаа бөгөөд тус дансны үр дүнгээс энэ үзүүлэлтийг тооцох боломжтой.

Ус

Ус бол хүмүүс болон бусад организмын оршин тогтнох үндэс суурь юм. Манай улс усны нөөцийн хомсдолтой орны тоонд ордог. Одоогийн байдлаар усны хэмжээ, чанар, гүний усны экосистемийн эрүүл мэндийг харгалзан үзсэн усны мэдээлэл байхгүй байна.

БОЭЗДС-ийн дэд данс Усны дансыг байгуулахаар ажиллаж байна. Дансны үзүүлэлтээс боломжтой үзүүлэлтийг сонгон авч хэмжих боломжтой.

Агаар

Агаар мандал бол дэлхий дээрх бүх экосистемийн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Агаар мандал нь дэлхийн, бүс нутгийн болон орон нутгийн уур амьсгалыг зохицуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд дэлхий дээрх амьдралыг дэмждэг. Хүлэмжийн хий нь агаар мандалд байгалийн жамаар үүсч, нарны илч дулааныг барьж дэлхийн гадаргуугийн температур амьдралыг тэтгэх боломжийг олгодог. Хүний үйл ажиллагаа нь эдгээр хийнүүдийн агаар мандлын концентрацийг нэмэгдүүлж, улмаар уур амьсгалын өөрчлөлтөд хувь нэмэр оруулдаг.

БОЭЗДС-ийн дэд данс болох Агаар дахь ялгаруулалтын дансны үр дүнгээс хүлэмжийн хийн ялгарал болон агаар бохирдуулагч бусад бодисын хэмжээг тооцож гаргах бөгөөд эдгээрээс тохирох үзүүлэлтийг сонгон авах боломжтой.

Хог хаягдал

Хог хаягдал нь хүний амьдрах орчин, эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлдэг. Хүн амын өсөлт, хотжилт, үйлдвэржилтийн өсөлттэй холбоотойгоор хог хаягдлын хэмжээ эрчимтэй нэмэгдэж байна. Иймд хог хаягдлын менежментийг сайжруулах шаардлагатай.

БОЭЗДС-ийн дэд данс болох Хог хаягдлын дансны үзүүлэлтээр тооцох боломжтой.

Тав. Дүгнэлт, санал

Дэлхийн болон улс орнуудын нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшлийг хэмждэг үзүүлэлтүүдийг харьцуулан судалсны үндсэн дээр дараах саналуудыг гаргаж байна, Үүнд:

- Нийгмийн хөгжлийг дан ганц эдийн засгийн хөгжлөөр хэмжихээс гадна нийгэм, байгаль орчны үзэгдлийг хэмжсэн үзүүлэлтийг эдийн засгийн үзүүлэлттэй уялдуулан судлах шинэ хандлага бий болж байна.
- Хэдийгээр манай улсын хувьд орон нутгийн түвшинд хөгжлийн индекс тооцож байгаа ч гэсэн Дэлхийн санаачилгад нэгдэн нийгэм-эдийн засгийн хөгжил дэвшлийг харуулсан **үндэсний хэмжээний** нэгдсэн индекс тооцох аргачлал боловсруулах шаардлагатай байна.
- Улс орнуудын туршлагаас үзэхэд дан ганц Статистикийн байгууллагаас гадна олон талын оролцоог хангаж үзүүлэлтийн сонголтыг хийх, аргачлалыг хамтран боловсруулдаг байна.
- Холбогдох салбарын мэргэжилтэн, судлаачид, бодлого боловсруулагчдын санал, зөвлөгөөг тусгасны үндсэн дээр Монгол Улсын нийгмийн хөгжлийг хэмжих үзүүлэлтийг сонгох нь зүйтэй. Тиймээс үндэсний хэмжээний нэгдсэн индекс тооцоход талуудын оролцоог хангаж ажиллах шаардлагатай байна.
- Хүний хөгжлийн индексийн хамрах хүрээг өргөжүүлэх замаар үндэсний хэмжээний хөгжлийн индексийг тооцох боломжтой гэж үзэж байна.
- Бусад улсын болон өөрийн улсад тооцож байгаа туршлага, мэдээллийн боломжит байдал зэрэгт тулгуурлан Монгол улсын сайн сайхан аж байдлыг хэмжиж болох 10 бүлгийн 39 үзүүлэлтийг үндэслэл, мэдээллийн эх үүсвэрийн хамт бэлтгэн, **Хавсралт. 1** –д харуулав.
- Эдгээр санал болгож буй үзүүлэлтийн талаар холбогдох байгууллагаас санал авах, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, эрдэмтэн судлаач, нийгмийн бүлгийн төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулах хэрэгтэй байна.
- Цаашид нэгдсэн индекс тооцох аргачлал боловсруулж, батлагдсан аргачлалын дагуу тооцооллыг хийж нийтэд тархааж байх шаардлагатай байна.
- Хавсралт.1-д санал болгож байгаа үзүүлэлтээс гадна зарим субъектив үзүүлэлтүүдийг оруулж болно. Үүний тулд тусгайлсан асуулга судалгаа явуулах шаардлагатай.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Mike Salvaris, (2013). *Measuring the Kind of Australia We Want: ANDI, the GDP and the Global Movement to Redefine Progress*. Australian Economic Review, March 2013 v 46 no 1
- ABS, (2012). *Measures of Australia's Progress 2012 Is life in Australia getting better?©*
Commonwealth of Australia 2012. Produced by the Australian Bureau of Statistic
- Joseph E. Stiglitz, Jean-Paul Fitoussi and Martine Durand, (2018). *"Beyond GDP Measuring What Counts for Economic and Social Performance, OECD publication*.
- Scott Stern, Petra Krylova & Jaromir Harmacek (2020) *Social progress index: Methodology Summary*,
- ҮСХ, (2019) *Хүний хөгжлийн индекс*, Улаанбаатар.
- ҮСХ, (2017) *Нийслэлийн эрүүл аюулгүй байдлын индекс тооцох аргачлал*, Улаанбаатар
- ХНХСИ, 2020. *Төгсгөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа*, Улаанбаатар.

Цахим хуудас

- <http://www.andi.org.au/>
- <https://nccdh.ca/resources/entry/canadian-index-of-wellbeing>
- <http://www.oecdbetterlifeindex.org/>
- <https://www.socialprogress.org/>
- [https:// www.statistik.at/web_en/statistics/-----/hows_austria/index.html.](https://www.statistik.at/web_en/statistics/-----/hows_austria/index.html)
- [https:// www.findikaattori.fi/en/hyvinvointi.](https://www.findikaattori.fi/en/hyvinvointi)
- [https:// www.gut-leben-in-deutschland.de/static/LB/en](https://www.gut-leben-in-deutschland.de/static/LB/en)
- [https:// www.cbs.gov.il/statistical/stat151_eng.pdf](https://www.cbs.gov.il/statistical/stat151_eng.pdf)
- [https:// www.cao.go.jp/keizai2/koufukudo/pdf/koufukudosian_english.pdf](https://www.cao.go.jp/keizai2/koufukudo/pdf/koufukudosian_english.pdf)
- [https:// www.japanfs.org/en/news/archives/news_id032635.html.](https://www.japanfs.org/en/news/archives/news_id032635.html)
- [https:// www.cbs.nl/pdf/2015-a324-pub.pdf](https://www.cbs.nl/pdf/2015-a324-pub.pdf)
- [https:// www.cbs.nl/en-gb/news/2017/07/cbs-to-compile-a-monitor-of-well-being.](https://www.cbs.nl/en-gb/news/2017/07/cbs-to-compile-a-monitor-of-well-being)
- [https:// www.kazalniki-blaginje.gov.si/en/wb-slo.html.](https://www.kazalniki-blaginje.gov.si/en/wb-slo.html)
- <https://www.legalinfo.mn/annex/details/8331?lawid=13231>
- <https://www.legalinfo.mn/law/details/10549>
- [https://www.1212.mn//](https://www.1212.mn/)

Хавсралт 1. Монгол Улсын сайн сайхан байдлыг хэмжих үзүүлэлт /төсөл/

№	Бүлэг	Үзүүлэлт	Үндэслэл	Мэдээллийн эх үүсвэр	
I	Эдийн засаг	1	Нэг хүнд ногдох ҮНО	Үндэсний нийт орлого бол зөвхөн Монголын харьяат иргэдийн хэрэглээний бараа, үйлчилгээг худалдан авах чадавхийн үзүүлэлт юм.	Нэг хүнд ногдох үндэсний нийт орлого
		2	Хөрөнгө оруулалт	Хөрөнгө оруулалт нь ААНБ, иргэдийн хуримтлалыг шинээр бий болгох, түүний техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэн өргөтгөх, сайжруулахад зориулагддаг.	Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрээр
		3	Бүтээмж	Бүтээмж нь улс оронд бий болсон үйлдвэрлэл, үйлчилгээний үр ашгийн илэрхийлдэг.	Бүтээмж
II	Эрүүл мэнд	4	Дундаж наслалт	Дундаж наслалт нь амьдралын чанараас илүү амьдралын тоо хэмжээнээс хамаарч хүн амын эрүүл мэндийг тодорхойлдог. Цаг хугацаа өнгөрөх тусам систем, үйлчилгээ сайжирснаар хүн амын эрүүл мэндийн байдал хэрхэн өөрчлөгдөж байгааг мэдээлэхэд дундаж наслалтын чиг хандлагыг ашиглаж болно.	Хүн амын дундаж наслалт
		5	Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын эзлэх хувь	Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын эзлэх хувь нь тухайн хүн амын биеийн эрүүл мэндийн үзүүлэлт юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний асран хамгаалагчдын хувьд нийгмээс тусгаарлагдах байдалд хүрдэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын түвшин бага байх нь тухайн өрхийн төдийгүй, нийгмийн аж байдалд эерэг нөлөөтэй байна.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нас, хүйс, аймгаар
		6	Зүрх судасны өвчлөл	Зүрх, судасны өвчлөл нь манай улсын хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан юм. Иймээс зүрх судасны өвчлөл бага байх нь Манай улсын хувьд хүн амын эрүүл хүн мэнд сайжирч байгааг харуулна.	Нас баралт, зонхилох өвчний ангилалаар
		7	Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал	Энэ үзүүлэлт нь эмнэлгийн үйлчилгээний хүртээмж, эрүүл мэндийн салбар дахь засгийн газраас өгч буй ач холбогдлыг илэрхийлдэг.	Улсын төсвийн зарлага, төсвийн ерөнхийлөн захирагчаар

III	Боловсрол	8	0-5 настай хүүхдийн цэцэрлэгт хамрагдалтын хувь	СӨБ-ын байгууллагад хамрагдах нь хүүхдүүдийн нийгэм, сэтгэл хөдлөл, хөгжил, боловсролын үр дүнд эерэгээр нөлөөлдөг. Энэ нөлөө нь орлого, боловсролын түвшин доогуур, эсвэл амьдралын боломж тааруу гэр бүлийн хүүхдүүдийн дунд мэдэгдэхүйц байна.	СӨБ-ын байгууллагад хамрагдсан хүүхдийн тоо
		9	20-24 настай залуусын дунд бүрэн дунд боловсролтой залуусын эзлэх хувь	Бүрэн дунд боловсролын гэрчилгээ авах нь ажиллах хүчинд орох эхний алхам юм. Ахлах сургуулиа дүүргэх нь ирээдүйн боломжит орлого, нийгэм эдийн засгийн статустай холбоотой тул амьдралын түвшин, эрүүл мэндтэй нягт уялдаатай байдаг.	ХӨАМС
		10	ЭЕШ-ын дундаж оноо	Энэ нь боловсролын чанарыг илэрхийлэх үзүүлэлт юм.	Элсэлтийн ерөнхий шалгалтын дүн
		11	ИДС болон техникийн болон мэргэжлийн боловсролын байгууллага төгсөгчдийн хөдөлмөрийн насны хүн амд эзлэх хувь	Боловсрол нь хүмүүсийн амьдралын түвшинг дээшлүүлэх, мэдлэг, ур чадварыг хөгжүүлэхэд тусалдаг. Хувь хүмүүсийн хувьд боловсрол нь өндөр цалинтай ажил мэргэжил, илүү сайн сайхан амьдралд хүргэх гол хүчин зүйл гэж үздэг. Харин улс үндэстний хувьд чадварлаг хүний нөөцтэй байх нь эдийн засгийн хөгжил, амьдралын нөхцөлийн сайжруулалтад туслах чухал үүрэг гүйцэтгэдэг.	Их дээд сургууль, коллежийн төгсөгчид
		12	Нэг хүнд ногдох боловсролын зардал	Энэ үзүүлэлт нь боловсролын хүртээмж, боловсролын салбар дахь засгийн газраас өгч буй ач холбогдлыг илэрхийлдэг.	ТЕХНИКИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫГ ТӨГСӨГЧИД БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ЗАРДАЛ
IV	Өрхийн амьжиргаа	13	Өрхийн жилийн дундаж мөнгөн орлого	Мөнгөн орлого нь өрхийн сайн сайхан амьдрахад чухал ач холбогдолтой бараа, үйлчилгээ худалдан авахад хангалттай мөнгө байгаа эсэхийг тодорхойлж өгдөг. Дээд боловсрол, амралт, чөлөөт цагаа өнгөрөөх боломж битгий хэл хоол хүнс, орон байр, хувцас хунар хүртээмжтэй байх нь орлогод ихээхэн нөлөөлдөг нөөцийн жишээ юм. Үүний үр дүнд дундаж орлого өндөр байх нь хүн амын сайн сайхан байдлын түвшинг илтгэнэ.	Нэг өрхийн жилийн дундаж орлого

		14	Жини коэффициент (орлогын ялгаа)	Орлогын тэгш бус хуваарилалт нь санхүүгийн тогтворгүй байдал, эдийн засгийн өсөлт муу байгаатай холбоотой тул сайн сайхан байдалд сөргөөр нөлөөлдөг. Эдгээр нөхцөл байдал нь засгийн газар олон нийтийн боловсрол, эрүүл мэнд, амьдралын чанарт чухал шаардлагатай үйлчилгээнд хөрөнгө оруулах боломжтой мөнгөний хэмжээ буурахад хүргэж болзошгүй юм. Жини коэффициент өндөртэй улсад өрхийн өрийн хэмжээ ихэвчлэн өндөр байдаг.	Тэгш бус байдал, Жини коэффициент, улирлаар
		15	Бага орлогын бүлэгт хамаарах өрхийн эзлэх хувь	Бага орлоготой байх нь бие бялдар, сэтгэцийн эрүүл мэндийн түвшин доогуур, боловсрол эзэмших боломж хомс, амьдралын боломж тааруу байх зэрэг олон бэрхшээлтэй холбоотой байдаг. Иймээс бага орлогын хязгаараас доогуур орлоготой хүмүүсийн тоо буурч байгаа нь хүн амын сайн сайхан байдлын эерэг үзүүлэлт юм.	Өрхийн бүлэглэлт, мөнгөн орлогоор, дүнд эзлэх хувиар, оны үнээр
		16	Хүнсний аюулгүй байдал дунд зэрэг эсвэл хүнд түвшинд хамаарах өрхийн эзлэх хувь	Хүнсний аюулгүй байдал нь эрүүл мэндэд муугаар нөлөөлөх, архаг өвчний тархалт, сэтгэлийн хямрал зэрэг олон бэрхшээлтэй холбоотой байдаг.	ӨНЭЭС

V	Хөлөлмөр эрхлэлт	17	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	Хөдөлмөр эрхлэлт нь хүн амын санхүүгийн тогтвортой байдалтай холбоотой юм. Түүнчлэн ажил эрхлэлт нь өөрийгөө үнэлэх үнэлэмжийг дээшлүүлэх, нийгмийн харилцаанд илүү их хамрагдах, зорилгоо хуваалцахад хувь нэмэр оруулдаг. Ажил эрхлэлт нь сэтгэцийн эрүүл мэнд, сайн сайхан байдлын өндөр түвшин, олон тооны чөлөөт цаг, боловсролын боломжоос гадна илүү чанартай хоол хүнс, орон байраар хангах санхүүгийн боломжуудтай холбоотой юм. Тиймээс ажил эрхлэлтийн түвшин өндөр байгаа нь хүн амын сайн сайхан байдлыг харуулж байна.	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин
		18	Урт хугацаанд ажилгүй байгаа хүн амын эзлэх хувь	Ажилгүйдэл нь санхүүгийн тогтворгүй байдал, стресс, өөрийгөө үнэлэх чадварыг бууруулж, улмаар сэтгэцийн болон бие бялдрын эрүүл мэнд, эрүүл мэндэд ноцтой нөлөө үзүүлдэг. Иймээс урт хугацааны ажилгүйдлийн түвшин бага байгаа нь хүн амын амьжиргааны түвшинг харуулж байна.	Хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшин
		19	Дундаж цалин	Зохистой ажил эрхлэлтийн голлох үзүүлэлт нь дундаж цалин болдог. Мөн цалин нь өрхийн орлогийн үндсэн эх үүсвэрийг бүрдүүлнэ.	Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин
		20	Долоо хоногт үндсэн ажил дээрээ 40-аас дээш цагаар ажилладаг хүмүүсийн эзлэх хувь	Олон цагаар ажиллах нь эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй. Түүнчлэн гэрээсээ хол олон цагаар ажиллах нь гэр бүлийн харилцаа, сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, хүүхдүүддээ тавих анхаарал, халамж багасч үүнтэй холбоотой бэрхшээлүүд гарч болзошгүй юм. Улмаар олон цагаар ажилладаг хүн амын эзлэх хувь буурах нь хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх үзүүлэлт юм.	Цаг ашиглалтын судалгаа

		21	Цалин хөлстэй ажиллагчдын ажлын байрандаа хүрэх дундаж хугацаа	Ажилдаа явах хугацаа уртсах нь сайн сайхан байдлын олон асуудалд сөргөөр нөлөөлдөг. Ажил, амьдралын тэнцвэрт байдлыг бууруулж, амьдралын ерөнхий сэтгэл ханамжийг бууруулдаг. Цаашилбал, түгжрэл ихтэй замын хөдөлгөөний ачаалал нь стресс, сэтгэл санааны байдал, хөдөлгөөний хомсдол, хүлэмжийн хий, бохирдол зэрэг байгаль орчинд хор хөнөөлтэй.	Цаг ашиглалтын судалгаа
VI	Гэмт хэрэг	22	Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, гэмт хэргийн ангиллаар	Судалгаанаас харахад гэмт хэргийн ноцтой байдал нэмэгдэх нь хүмүүсийн болон нийгмийн амьдралын чанарыг эрс бууруулдаг. Иймээс хүнд гэмт хэргийн эзлэх хувь нийт бүртгэгдсэн гэмт хэрэгт бага байх нь сайн.	БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО, хэргийн ангиллаар, жил
		23	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэх зөрчлийн тоо	Гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн тоо буурах нь гэр бүлийн амгалан тайван байдал нэмэгдэж буйг илтгэнэ.	Бүртгэгдсэн зөрчил
		24	Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг	Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тал нь согтуу байх үедээ үйлдсэн байдаг. Хэрэв согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тоо буурвал нийт гэмт хэргийн тоо буурах юм.	Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, үйлдэгдсэн байдлаар
VII	Орон сууцны нөхцөл	25	Орон сууцанд амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь	Хүний амьдрах орчин буюу орон гэр нь хүмүүсийн сайн сайхан, тав тухтай байдлын үндэс суурь юм. Орон сууц нь хүмүүсийг тайван амрах, аюулгүй байх нөхцөлөөр хангадаг. Иргэдийнхээ хэрэгцээнд нийцсэн орон сууцны хүртээмжийг сайжруулах нь Монголчуудын амьдрал сайжирч байгаа эсэхийг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм. Манай орны хувьд гэр болон орон сууц гэсэн сууцны 2 үндсэн төрөл байдаг. Орон сууц нь гэрийг бодвол илүү тав тухтай байж болох юм. Тиймээс орон сууцанд амьдардаг өрхийн тоо нь өсөх нь улс орны хөгжилд ахиц гарч буйг илэрхийлэх боломжтой.	ТӨВЛӨРСӨН БОЛОН БИЕ ДААСАН ИНЖЕНЕРИЙН БҮРЭН ХАНГАМЖТАЙ ОРОН СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХ

		26	Нэг хүнд ногдох м.кв-ын хэмжээ	Нэг хүнд ногдох м.кв нь хангалттай зай талбайд амьдарч байгаа эсэхийг харуулна. Хангалттай зай талбайд амьдарч чадахгүй байх нь хүний оюуны болон бие физиологийн эрүүл мэнд, бусадтай харилцах харилцаа, хүүхдийн хөгжилд сөрөг нөлөөтэй.	ХАӨМС
		27	Өрхийн зардалд орон сууцны (ус, дулаан, цахилгаан, СӨХ гэх мэт) төлбөрийн эзлэх хувь	Орон байр нь хүний үндсэн хэрэгцээг хангах хамгийн чухал хэсэг бөгөөд энэ нь зөвхөн 4 ханатай, дээвэртэй байх тухай ойлголт биш юм. Орон байр нь хүнийг унтаж амрах, амьдрахад тухтай, аюулгүй, хувийн орон зай бүхий байх хэрэгтэй. Уг категорийн 3 үзүүлэлтүүд нь хүн амы амьдарч буй орон байр шаадлага хангасан эсэхийг харуулна. Орон сууцны зардал нь өрхийн зардлын томоохон хэсгийг бүрдүүлэх бөгөөд OECD-ын орнуудад дунджаар өрхийн орлогын 20%-ийг, Шинэ Зеланд улсад 26%-ийг, БНСУ-д 15%-ийг орон гэртэй байхад зарцуулж байна.	ӨНЭЗС
VIII	Чөлөөт цаг	28	Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаанд зарцуулж буй цаг	Хүн амын дунд өөрийгөө хөгжүүлэх болон чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх үйл ажиллагаанд зарцуулж буй цаг нэмэгдэх нь хүн амын амьдралын чанарт сайнаар нөлөөлөөд зогсохгүй сэтгэцийн эрүүл мэндэд эерэг нөлөөтэй.	Цаг ашиглалтын судалгаа
		29	Олон нийтийн арга хэмжээ, бусадтай харилцахад зарцуулж буй цаг	Олон нийтийн арга хэмжээнд оролцож, бусадтай харилцах цаг нэмэгдэх нь хүн амын амьдралын сайн сайхан байдалд эерэг нөлөөлнө.	Цаг ашиглалтын судалгаа

IX	Ардчилал , засаглал	30	Сонгуулийн ирцийн хувь	Хүмүүс сонгуульд оролцох нь ардчиллаар олгогдсон эрхээ эдэлж байгааг илэрхийлдэг. Ирц өндөр байх нь иргэдийн ардчилсан оролцоо өндөр, сонгуулийн үр дүнг сонирхдог болохыг илэрхийлдэг бол бага байх нь улс төрийн үйл явцыг үл тоомсорлох эсвэл хоёрдмол байдалтай байгааг харуулж байна.	Сонгогчдын оролцоо
		31	Ахмад, залуу сонгогчдын оролцооны зөрүү, хувиар	Улс төрчид наснаас үл хамааран бүх ирэдийн хэрэгцээ, ашиг сонирхлыг хангахын тулд бүх насны иргэд сонгох эрхээ эдлэх нь чухал юм.	СЕХ
		32	Парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь	Хүн амын дунд эрэгтэй, эмэгтэй хүмүүс адил тэгш төлөөлөлтэй байдаг тул ардчилсан шийдвэр гаргах үйл явцад ижил тэгш төлөөлөлтэй байх ёстой. Тэнцүү төлөөлөл нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн амьдралын чанарт нөлөөлөх асуудлуудыг тавьж, шийдвэрлэх нөхцлийг бүрдүүлдэг.	МУ-ын их хурлын гишүүд, насны бүлэг, хүйсээр
X	Байгаль орчин	33	Агаарын бохирдол (PM 2.5)	Гадаад орчны бохирдол нь хүрээлэн буй орчныг илэрхийлэгч нэг чухал үзүүлэлт юм. Дэлхийн хэмжээнд хот орчмын агаарын бохирдлын хэмжээ нэмэгдсээр байгаа бөгөөд хугацаанаас өмнөх төрөлтөд нөлөөлөх байгал орчны үндсэн хүчин зүйл болдог.	Агаар дахь бохирдуулагч бодисын агууламж
		34	Хүлэмжийн хийн ялгарал (CO2)	Уур амьсгалын өөрчлөлт нь байгаль орчны нөөцөд сөргөөр нөлөөлдөг. Ус зэрэг хүн төрөлхтөнд амин чухал байгалийн нөөцийг зүй бусаар ашиглах нь өвчин, тахалд нэрвэгдэх, хүчирхийлэл, мөргөлдөөн нэмэгдэхэд хүргэх аюултай.	Хүлэмжийн хийн шингээлт, ялгарал
		35	Өрхийн эрчим хүчний хэрэглээ	Бидний амьдрал бүх талаараа эрчим хүчнээс хамааралтай байдаг. Гэр орноо халааж, хоолоо хийхээс эхлээд тээврийн хэрэгслээ хөдөлгөхөд хүртэл эрчим хүч хэрэгтэй.	https://www.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Erchikmkhuch.pdf&ln=Mn

		36	Эрчим хүчний анхдагч бүтээгдэхүүн, тера жоуль	Эрчим хүчний анхдагч бүтээгдэхүүн болох нүүрс, газрын тос, байгалийн хий, нар, салхи, усны эрчим хүч, биомасс зэргээс гарган авч буй эрчим хүчний хэмжээг тодорхойлсноор айл, өрх, үйлдвэрлэл, үйлчилгээнд шаардлагатай эрчим хүчээр хангах замаар сайн сайхан байдалд нөлөөлдөг.	https://www.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Erchikmhuch.pdf&ln=Mn
		37	Усны хэрэглээ	Ус бол хүмүүс болон бусад организмын оршин тогтнох үндэс суурь юм. Усны хомсдол нь хүрээлэн буй орчин, хүнсний үйлдвэрлэл, амьтны амьдрал, хүн амын эрүүл мэнд, сайн сайхан байдалд сөргөөр нөлөөлдөг. Манай улс усны нөөцийн хомсдолтой орны тоонд ордог.	https://www.eic.mn/statistic/box2.php БОЭЗДС-ийн дэд данс Усны данс
		38	Хог хаягдал	Хог хаягдал нь хүний амьдрах орчин, эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлдэг. Хүн амын өсөлт, хотжилт, үйлдвэржилтийн өсөлттэй холбоотойгоор хог хаягдлын хэмжээ эрчимтэй нэмэгдэж байна. Иймд хог хаягдлын менежментийг сайжруулах шаардлагатай.	https://www.eic.mn/statistic/box6.php БОЭЗДС-ийн дэд данс болох Хог хаягдлын дансны үзүүлэлт
		39	Уул уурхайн нөхөн сэргээгдсэн газар	Газрын доройтлын 56 хувь нь байгалийн үзэгдэлтэй холбоотой гэсэн судалгаа байдаг. Хэдийгээр уул уурхайн олборлолтоос үүдэн газар ихээр эвдэрч байгаа ч нөхөн сэргээлтийг хийх нь бид газраа тогтвортой ашиглах нөхцөл бүрдэнэ. Иймд нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ нь газартай холбоотой үзүүлэлт байж болох юм.	https://www.eic.mn/statistic/box1.php